

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ

2010 оны 7 дугаар сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХЭЭС ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ГАРГАХ МАГАДЛАЛД ТАВИГДАХ ЗАРИМ ШААРДЛАГЫН ТУХАЙ

Эрүүгийн хэргийн талаар давж заалдах шатны шүүхээс магадлал гаргахад тавигдах хуульд заасан шаардлагуудыг нэг мөр, зөв ойлгож хэрэгжүүлэх, давж заалдах шатны шүүхээс гарч буй эрхийн актуудын боловсруулалтыг сайжруулах зорилгоор Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ЗӨВЛӨМЖЛӨХ НЬ:

1.Магадлал боловсруулж гаргахад анхан шатны шүүхийн шийтгэх болон цагаатгах тогтоол гаргахад тавигддаг Эрүүгийн Байцаан Шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлд заасан "хууль ёсны ба үндэслэл бүхий" байх шаардлага нэгэн адил хамаарна. Иймд энэ талаарх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох заалтууд болон "Шүүхийн шийдвэрийн тухай" Улсын Дээд шүүхийн 2006 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 21 дүгээр тогтоол, мөн "Шүүхийн шийтгэх ба цагаатгах тогтоол боловсруулах аргачлалын тухай" Улсын Дээд шүүхийн 2006 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн зөвлөмж зэргийг давхар судалбал зохино.

2.Шүүхийн шийдвэр нь хэргийн оролцогч нар уншиж танилцахад ойлгомжтой, тодорхой, хуулийн үг хэллэгээр томъёолж бичигдсэн байх ёстой.

3.Давж заалдах гомдол гаргах эрхгүй этгээд давж заалдах гомдол гаргасан, эсхүл Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар гомдол гаргах, эсэргүүцэл бичиж болохгүй тохиолдолд давж заалдах гомдол, эсэргүүцэл бичсэн нь тогтоогдвол давж заалдах шатны шүүх гомдол, эсэргүүцлийг хэлэлцэхгүй орхих ба энэ тохиолдолд шүүхээс магадлал гаргах шаардлагагүй.

Мөн шүүхийн тогтоолд гомдол гаргасан, эсэргүүцэл бичсэн этгээд давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдаан эхлэхийн өмнө өөрийнхөө гомдол, эсэргүүцлийг, түүнчлэн дээд шатны прокурор нь доод шатныхаа прокурорын бичсэн эсэргүүцлийг буцаан авсан, эсхүл шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд түүнийг гардуулснаас хойш хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 304 дүгээр зүйлийн 304.1-д заасан 14 хоногийн хугацааг хэтрүүлж давж заалдах гомдол гаргасан, эсэргүүцэл бичсэн нь тогтоогдвол давж заалдах шатны шүүх хэргийг хэлэлцэж магадлал гаргах шаардлагагүй бөгөөд хэргийг тухайн шүүхэд нь буцаана.

4.Давж заалдах шатны шүүхээс гарах магадлал нь удиртгал, тодорхойлох, тогтоох хэсгүүдээс бүрдэнэ.

Шүүгдэгчийн гэм буруу тогтоогдсон эсэх, хэргийн зүйлчлэл болон шүүгдэгчид оногдуулсан ял түүний гэм бурууд тохирсон эсэх талаар гаргасан давж заалдах гомдол, эсэргүүцлийн үндэслэлд зохих хариулт өгч чадаагүй давж заалдах шатны шүүхийн магадлалыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 325 дугаар зүйлийг зөрчсөн буюу хуульд заасан шаардлага хангаагүй гэж үзнэ.

5.Магадлалын удиртгал хэсэг

5.1.Давж заалдах шатны шүүхээс гаргах магадлалын удиртгал хэсэгт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 325 дугаар зүйлийн 325.1.1, 325.1.2-т заасны дагуу магадлалыг хэзээ, хаана гаргасан болон магадлал гаргасан шүүх, шүүх бүрэлдэхүүн болон давж заалдах шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэхэд оролцсон прокурор, өмгөөлөгч, шийтгүүлсэн буюу цагаатгагдсан этгээд, хохирогч, түүнчлэн иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч нараас гадна шүүх хуралдааны нарийн бичгийн даргын нэрийг бичнэ.

5.2.Магадлалын энэ хэсгийг бичихдээ сунжирч үргэлжилсэн урт өгүүлбэрээс татгалзаж, эмх цэгцтэй хэлбэрийг баримжаа болгох нь зүйтэй.

5.3.Магадлалын удиртгал хэсэгт холбогдогч этгээдийн /яллагдагч, шүүгдэгч, ялтан/ биеийн байцаалтыг бичих талаар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заагаагүй боловч тухайн этгээдийн "овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, давж заалдах шатны шүүхээр хэрэг хянан хэлэлцэх үед түүний оршин суугаа болон ажлын газар, эрхэлсэн ажил, албан тушаал,

боловсрол, мэргэжил, гэр бүлийн байдал, урьд ял шийтгүүлсэн эсэх, хэрэгт ач холбогдол бүхий биеийн байцаалтын талаарх бусад мэдээг" түүний холбогдсон хэргийн товч агуулгын хамт магадлалын удиртгал хэсэгт бичих нь зүйтэй.

5.4.Түүнээс гадна магадлалын удиртгал хэсэгт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 325 дугаар зүйлийн 325.1.3, 325.1.4-т заасны дагуу анхан шатны шүүхийн шийдвэрийн товч агуулга болон шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах гомдол, эсэргүүцэл бичсэн этгээдийн гомдол, эсэргүүцлийн агуулга, товч үндэслэлийг бичнэ.

Мөн магадлалын удиртгал хэсэгт давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцсон яллах, өмгөөлөх тал болон бусад оролцогч нарын гаргасан тайлбар, дүгнэлтийн товч агуулгыг тусгана.

6.Магадлалын тодорхойлох хэсэг

6.1.Магадлалын тодорхойлох хэсэгт анхан шатны шүүхийн шийтгэх, цагаатгах тогтоол болон бусад шийдвэрт дурьдсан дүгнэлт хэргийн жинхэнэ байдалтай нийцсэн талаарх дүгнэлтийг хийх шаардлагатай.

Үүний тулд давж заалдах шатны шүүх хуралдаанаар нотлох баримтыг шинжлэн судлаад тогтоогдсон гэж үзсэн үйл баримт, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон бүх нөхцөл байдлыг прокуророос шүүхэд шилжүүлсэн яллах дүгнэлтийн хүрээнд товч тодорхой, ойлгомжтой, эргэлзээгүй, итгэл үнэмшил төрүүлхүйц байдлаар буюу түүнийг үндэслэн гэмт хэргийн зүйлчлэлийг зөв тогтоох боломжтой байдлаар тодорхойлж бичнэ. Үүнд: Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 296 дугаар зүйлийн 296.1-д зааснаар "гэмт хэрэг үйлдсэн газар, цаг, арга, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний хэмжээ, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл"-ийн талаар дурдахаас гадна шүүгдэгч гэм буруугийн талаар ямар байр суурьтай байгааг, мөн шүүхийн дүгнэлтийн үндэслэл болсон нотлох баримтуудын агуулга, хэргийн талаар шүүхийн хийсэн хууль зүйн дүгнэлт, шүүхээс бусад нотлох баримтыг болон давж заалдах гомдол, эсэргүүцлийг няцаан үгүйсгэсэн үндэслэлийг логик дэс дараалалтайгаар бичсэний дараа анхан шатны шүүхийн тогтоолд дурьдсан дүгнэлт хэргийн жинхэнэ байдалтай нийцсэн, хэргийн зүйлчлэл зөв, шүүхээс оногдуулсан ял ялтны гэм буруу болон хувийн байдалд тохирсон, шүүх хохирлыг зөв шийдвэрлэсэн талаарх дүгнэлтийг бичнэ.

6.2.Харин анхан шатны шүүхээс хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаасан шүүхийн тогтоол, захирамж үндэслэлтэй зөв гарсан талаарх дүгнэлтийг хийхдээ давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэргийн талаар тогтоогдсон үйл баримт, шүүгдэгчийн гэм буруугийн талаар дүгнэж бичих шаардлагагүй, харин давж заалдах гомдол, эсэргүүцлийг хүлээж авах боломжгүй шалтгаан нөхцөл, түүнчлэн анхан шатны шүүхийн тогтоол, захирамжид зааснаас гадна хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад зайлшгүй шалгах шаардлагатай зүйлүүдийн талаар давж заалдах шатны шүүхээс нэмж тогтоосон зүйлүүдийг бичих нь зүйтэй.

6.3.Шүүгдэгч нь Эрүүгийн хуульд заасан өөр өөр төрлийн хэд хэдэн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн бөгөөд давж заалдах эрх бүхий этгээд шүүхийн шийдвэрийг бүхэлд нь давж заалдсан тохиолдолд анхан шатны шүүхээс шүүгдэгчийн зарим үйлдэлд хийсэн дүгнэлт, оногдуулсан ялыг үндэслэлтэй, харин тогтоолын бусад заалтыг хүчингүй болгож хэргийг анхан шатны шүүх хуралдаанаар дахин хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзвэл энэ талаар магадлалд тодорхой дурьдаж байвал зохино.

6.4.Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтойгоор зөрчсөн гэсэн үндэслэлээр анхан шатны шүүхийн тогтоолыг хүчингүй болгохдоо Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 320 дугаар зүйлд зааснаар хэрэг хэлэлцэхэд оролцогчийн хуулиар хамгаалагдсан эрхийг хасах буюу хязгаарлах замаар, эсхүл бусад хэлбэрээр шүүхээс хэргийг бүх талаар хэлэлцэх явдалд саад болж, хууль ёсны ба үндэслэл бүхий тогтоол гаргахад сөргөөр нөлөөлсөн буюу нөлөөлж болохуйцаар энэ хуулийн шаардлагыг зөрчсөн талаарх тодорхой үйлдлийг дурьдаж бичнэ.

Тухайлбал, прокурор яллагдагчаар татах тогтоолыг батлаагүй, яллах дүгнэлт нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 218 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй, яллагдагчийн өмгөөлүүлэх эрхийг ноцтой зөрчсөн, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахдаа хуульд заасан хугацаа зөрчсөн, эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж нотлох баримт цуглуулсан, мөн ял сонсгохдоо яллагдагчийн эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах зэрэг хуульд заасан эрхийг эдлүүлээгүй, түүнчлэн шүүх хуралдааны явцад оролцогчийн хуулиар олгогдсон эрх зөрчигдсөн нь шүүхийн шийдвэр зөв шударга гарахад нөлөөлсөн зэрэг зөрчил илэрсэн боловч дээрх зөрчлийг арилгуулах талаар анхан шатны шүүх зохих арга хэмжээ аваагүй бол давж заалдах шатны тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах, эсхүл шүүх хуралдааны ажиллагаанаас хэргийг дахиж хэлэлцүүлж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах нь зүйтэй.

6.5.Шүүх нотлох баримтыг зөв үнэлсэн эсэх талаар дүгнэлт хийхдээ анхан шатны шүүх чухам ямар алдаа зөрчил гаргасан болон хэргийг дахин хэлэлцэхдээ урьд гаргасан алдааг зөвтгөж, хэргийг үндэслэлтэй зөв шийдвэрлэхийн тулд ямар арга